



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 9/70

Улаанбаатар хот

Байгууллагын цахим хавтасны  
бүрдүүлэлт, хандах эрхийг шинэчлэн  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.6, 35 дугаар зүйлийн 35.1, 46 дугаар зүйлийн 46.1, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/477 дугаар захирамжаар батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-ын 5.9, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын цахим хавтсанд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, цахим хавтсанд хандах хэлтэс, албан хаагчдын эрхийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан жагсаалтын дагуу баримт бичгийн бүрдүүлэлт хийж ажиллахыг нийт албан хаагчдад, серверийн зохион байгуулалт, баримт бичгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Байгууллагын баримт бичгийн цахим хавтсыг хөтлөх хэлтэс, албан хаагчийн эрхийг жагсаалтаар батлах тухай” Газрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/73 тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ